

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

“Түмэн шувуут” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Огноо: 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Цаг: 16:00 -17:55

Хурлын хэлбэр: Биечлэн оролцох /шууд дамжуулалттай/

Хурлын дарга: Ломбын Эрхэмбаяр

Хурлын нарийн бичгийн дарга: Болдбаатарын Нямбаяр

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн тоо: 167

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо: 166,755,827 ширхэг.

Хурлын ирц: 83,38%

Тусгай тэмдэглэл:

Хурлын дарга Л.Эрхэмбаяр: Энэ удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Шангрила зочид буудлын Бүүлрүүм1 танхимд зохион байгуулж байгаа бөгөөд хуралд оролцогсдын оролцоог хангах нээлттэй мэдээлэл өгөх үүднээс Түмэн шувуут ХК-ийн албан ёсны фээсбүүк цахим хуудсаар шууд дамжуулан хийж байгаа тухай танилцуулав. Мөн хуралд оролцохоор цахимаар бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчдийн гар утсанд 2022 оны 04-р сарын 22-ны өдрөөс эхлэн нэвтрэх код хаягийг санал өгөх кодын хамт илгээсэн болно. Бүртгэлийг www.investmentexpo.mn хаягаар цахимаар бүртгэсэн.

Хурлын дарга хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж хурлаар хэлэлцэх асуудал нэг бүрийг хэлэлцсэний дараагаар санал асуух, санал хэлэх, шүүмж хэлэхээр шийдвэрлэв.

ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

1 дэх асуудал: “Түмэн шувуут” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах;

2 дахь асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

3 дахь асуудал: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зардлын төсөвийг батлах

4 дэх асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг 2 жил байхаар Компанийн дүрмийн 9-р бүлгийн 3 дахь заалтад өөрчлөлт оруулахыг батлах

ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ

1 ДЭХ АСУУДАЛ:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Ж.Болд

“Түмэн шувуут” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ж.Болд 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлууд, оны онцлох үйл явдлууд, тухайн оны санхүүгийн тайлан болон цаашид хийхээр төлөвлөж байгаа зорилтуудынхаа тухай дэлгэрэнгүй мэдээллийг хувьцаа эзэмшигчиддээ танилцуулав. /тайланг хавсаргав./ Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай Төлөөлөн Удирдах Зөвлөл хурлаараа хэлэлцээд дүгнэлт гаргасан бөгөөд уг дүгнэлтийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Ц.Наран-Учрал нийт хувьцаа эзэмшигчдэд уншиж сонордуулав.

2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:

1. “Түмэн шувуут” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлав.

3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа
200,000,000	166,755,827	200,000,000	166,755,827	200,000,000	166,755,827
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
166,426,229	100%	355	0,00%	0	0%

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрөв.

2 ДАХЬ АСУУДАЛ: Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нямбаяр ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах видеог дэлгэцээр үзүүлэв.

Танилцуулгын гол агуулга: Кумулятив аргаар ердийн болон хараат бус гишүүнийг сонгох зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Мөн цахимаар хэрхэн саналаа өгөх зөвлөмжийг өгөв. Энэ зөвлөмж дээр шинээр журамд орсон өөрчлөлтийг мөн тусгаж заавар өгсөн болно.

1. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:

1. “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгов:

1.1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

- 1.1.1. Ломбо овогтой Эрхэмбаяр
- 1.1.2. Балай овогтой Тунгалаг
- 1.1.3. Жигжид овогтой Болд

- 1.1.4. Эрхэмбаяр овогтой Баяржаргал
- 1.1.5. Эрдэнэчулуун овогтой Жаргалхүү
- 1.1.6. Болдбаатар овогтой Бархасбадь
- 1.2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:
 - 1.2.1. Цэдэв овогтой Наран-Учрал
 - 1.2.2. Агипар овогтой Бакей
 - 1.2.3. Гочоо овогтой Мөнх-Эрдэнэ
2. Хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгож ТУЗ-ийн бүрэлдэхүүний талаарх олон нийтэд мэдээлж, шинээр сонгогдсон гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгов.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/-д үүрэг болгов.
2. Энэ асуудлаар санал хураасан дүн:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:

Овог нэр	Санал өгсөн эрх	Саналын хувь
Ломбо Эрхэмбаяр	337,733,078	22,7%
Балай Тунгалаг	333,824,852	22,50%
Жигжид Болд	260,236,168	17,54%
Эрхэмбаяр Баяржаргал	259,051,606	17,54%
Эрдэнэчулуун Жаргалхүү	60,004,047	4,04%
Болдбаатар Бархасбадь	59,574,869	4,01%

Үүнээс: Л.Эрхэмбаяр, Б.Тунгалаг, Ж.Болд, Б.Баяржаргал, Э.Жаргалхүү, Б.Бархасбадь нар сонгогдов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:

Овог нэр	Санал өгсөн эрх	Саналын хувь
Цэдэв Наран-Учрал	55,703,713	3,75%
Агипар Бакей	53,938,043	3,64%
Гочоо Мөнх-Эрдэнэ	63,755,281	4,30%

Үүнээс Ц.Наран-Учрал, А.Бакей, Г.Мөнх-Эрдэнэ нар сонгогдов.

3 ДАХЬ АСУУДАЛ:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Хурлын дарга Л.Эрхэмбаяр

Танилцуулгын гол агуулга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал, зардлын төсөвийг хэмжээг тогтоох тухай хэлэлцэв.

2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр

1. “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллыг хавсралтаар танилцуулав. (*Хавсралтаар: Ердийн болон хараат бус гишүүдийн цалинг улирал бүрийн тогтсон хурал хийж тогтмол 500,000 төгрөгийн цалин, хуралд оролцсон байдлаар тооцож ТУЗ-ийн 1 удаагийн хуралд оролцоход гишүүн тус бүр 300,000 төгрөгийн цалин авахаар танилцуулав.*)
2. Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэлтийг хийж ажиллахаар танилцуулав.

3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа
200,000,000	166,755,827	200,000,000	166,755,827	200,000,000	166,755,827
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
166,277,497	99,96%	1,871	0,00%	72,866	0,04%

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,96% нь зөвшөөрч, 0,00% нь татгалзаж, 0,04% нь түдгэлзэв.

4 ДАХЬ АСУУДАЛ:

Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Хурлын дарга Л.Эрхэмбаяр

Танилцуулгын гол агуулга: ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг 2 жил байхаар компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай хэлэлцэв.

Өөрчлөлт орох дүрмийн 9-р бүлэг 9.3 дахь заалт:

- ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа 2 (Хоёр) жил байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 2 жилийн дараах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд ТУЗ-ийн гишүүнийг хэдэн ч удаа улируулан сонгож болно.

Дээрх санал нь “Түмэн шувуут” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны хурлаас ТУЗ-д оруулсан санал бөгөөл 2022 оны 03-р сарын 14-нд хуралдсан ТУЗ-ийн хурлаар дэмжиж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулахаар танилцуулсан болно.

Уг саналын үдэслэл: ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа компанийн дүрмийн 9 дүгээр бүлгийн 3-дахь заалтад тусгасны дагуу 1 жил байдаг. Энэ хугацаа нь компанийн хувьд стратегия боловсруулах, залгамж чанараа сайжруулах, тогтвортой байдлыг хадгалах, аливаа үйл ажиллагааны үргэлжлэл, үр дүнг тооцох боломжтой байдалд сөргөөр нөлөөлөх талтай гэж үзэж байгаа тул ТУЗ-ийн

гишүүдийн бүрэн эрхийн хугацааг 1 жилээс дээш байхаар өөрчлөн оруулах” гэжээ. Иймд ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж 2 жил байхаар ХЭЭХ-д хэлэлцүүлж батлахаар тогтсоныг танилцуулав.

Энэ асуудлаар санал хураасан дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа
200,000,000	166,755,827	200,000,000	166,755,827	200,000,000	166,755,827
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
166,420,139	100%	3,516	0,00%	3,993	0,00%

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрч, 0,00% нь татгалзаж, 0,00% нь түдгэлзэв.

Энэхүү санал хураалтын дагуу тогтоолын төслийг баталж, хэрэгжилтэнд хяналт тавьж, хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид холбогдох бичиг баримтыг хүргэх, дүрмийн өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ж.Болд/ болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Нямбаяр/ нарт даалгаж байна.

АСУУЛТ ХАРИУЛТ:

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ:

-ХЭ: Ирэх жилд ямар хөрөнгө оруулалтын бодлого барьж ажиллах вэ?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Ирэх жил өндөглөгчийн 2 байрыг барьж, тоног төхөөрөмжийг угсарч ашиглалтанд оруулах, тэжээлийн үйлдвэрийн өргөтгөл, шувууны тоо толгойг 80,000-аар нэмэгдүүлэх зэрэг нийтдээ 7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэнэ.

-ХЭ: Ногдол ашиг олгох жил бүрийн тогтсон хувь хэд байдаг вэ?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Бид анх Хувьцаа гаргахдаа хэлсэн байгаа. 30%-иа ногдол ашиг болгон тараана гээд. Гэхдээ өнгөрсөн жил 2021 онд бид нийт ашгийнхаа 40%-ийг тараасан. Энэ жил тогтсон ёсоороо нийт ашгийнхаа 30%-ийг тараана. Учир нь хөрөнгө оруулалт маш их шаардлагатай байгаа.

-ХЭ: 2022 онд хувьцааны ханш ямар хуу байх бол?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Бид тэр ханшийн үзүүлэлтийг өсөх, унахыг урьдчилан тааж хэлэх боломжгүй. Харин хийдэг ажлаа хийдгээрээ л хийгээд явна. Ханш хэр зэрэг байхыг компаниас гадна иргэд, хувьцаа эзэмшигчид мэднэ гэдгийг хэлье.

-ХЭ: Хувьцааны ногдол ашгаа хэзээ өгөх вэ?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Хувьцаа эзэмшигч таны хувьцааны ногдол ашиг 2022 оны 07-р сарын 1-ний өдрийн дотор ҮЦТХТ-өөр дамжуулан өөрийн бүртгэлтэй үнэт цаасны компанитай холбогдож авна. 2021 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 10.4 төгрөгийг олгохоор ТУЗ-ийн хурлаас шийдвэрлэсэн.

-ХЭ: Шинээр байгуулж байгаа Түмэн шувуут-2 төсөл хэзээ дуусаж үр ашгаа өгч эхлэх вэ?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Бид энэ жил барагцаагаар 20 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг олон нийтээс босгож ажиллахаар төлөвлөж байгаа. Зарим ажил судалгааны түвшинд явагдаж байна. энэ ажил хийгдвэл бид төслөө үргэлжлүүлээд үлдсэн шувууны байруудаа барьж дуусгаад 2024 оноос жигдрэх юм. 2024 оноос бид үйлдвэрээ 100%-иар ажиллуулж эхэлнэ гэж ойлгож болно. Харин хонины махны кластер төсөл бол 2026 он хүрч байж жигдэрнэ гэсэн тооцоотой байгаа.

Хувьцаа эзэмшигч: Би танай шинээр баригдаж байгаа үйлдвэрүүдтэй танилцсан. Үнэхээр сайхан юм билээ. Нэг л юм таалагдаагүй. Энэ юу вэ гэхээр үйлдвэрээ тойроод та нар жорлон бариад байна. Хэд хэдэн жорлон байна. Өндөг, жорлон хоёр тохирохгүй гэж байна. энэ талаар тайлбар өгнө үү.

Үйлдвэрийн дарга Д.Баянмөнх: Сайн байна уу. Манай үйлдвэрийн үйл ажиллагаа стандартын дагуу баригдаж байгаа. Гаднаас харагдаж байгаа зүйл нь худаг юм байгаа шүү. Барилгын ажилчдад зориулж босгосон нэг модон 00 бий.

Ж.Болд: Таны саналыг сонслоо. Үйлдвэр барьж байх үед бол барилгын ажилчдын 00 бол тусдаа байдаг. Шувууны байрны ажилтнууд бол тийм 00-д орох боломжгүй. Хорио цээрийн дэглэмтэй байдаг тул бүх ажилтнууд боловсон бие засах газар ашигладаг юм шүү. Бид одоо 100 хувь цэвэр бохир ус нь холбогдсон боловсон 00-той. Та бүхэн маргааш очоод үзсэн ч манай үйлдвэрүүд бүгд боловсон 00-той байгаа.

Хувьцаа эзэмшигч Мөнхпүрэв: Дархан уул аймгаас ирж хуралдаа оролцож байгаа хүн байна аа. 2 жил гаруйн дараа та бүхэнтэйгээ, захиралтайгаа, хувьцаа эзэмшигч нартайгаа уулзсандаа баяртай байна аа. Надад нэг асуулт байна. Манай тэнд Хүслэн төв гээд хүнсний бөөний төв байгаа. Манай компаниас Хувьцаатай өндөг очдог юм. Тэр нь ерөөсөө сүүлийн үед ирэхгүй болсон. Эсвэл дундаас нь хүмүүс авчихаад байна уу. Тэрийг ойлгохгүй байна. Ер нь хөдөө аймгууддаа гэрээт борлуулагч байлгамаар байна шүү. Манай өндөг бол хэрэгцээ ихтэй байгаа. Авах гээд олдохгүй байгаа. Манай компани бол өснө өөдлөнө. Та бүхэн их зөв компанид хөрөнгө оруулсанд баярлаж байна. Амжилт хүсье.

Б.Мөнгөнтуяа: Сайн байцгаана уу. Борлуулалт хариусан албаны дарга байна. Мөнхпүрэв гуайн асуултанд би хариулья. Манай компани 2 жилийн өмнөөс эхлээд Хувьцаатай өндөг

гэдэг хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Хувьцаатай өндөг маань хагас сарын хугацаатай тасалдсан байгаа. Яагаад гэвэл ковидтой холбоотой, тээвэртэй холбоотой тасалдсан. Сарын өмнөөс дахин худалдаанд гаргаж эхэлсэн. Таны үйлчлүүлдэг Хүслэн төвд манай бүтээгдэхүүн очиж байгаа. Тухайн өндөг дээр QR код уншуулдаг нууцлалтай стикер байдаг. Тэр өндөг дээрх стикер эцсийн хэрэглэгчид очихдоо нууцлалтай байгаа. Хэрвээ QR нь уншигдсан байвал нууцлал нь алдагдсан байна гэсэн үг. Нууцлал алдагдаагүй үед бол хэн нэгэн хөндлөнгийн этгээд тэр QR кодыг уншуулах боломжгүй байгаа. Манай бүтээгдэхүүнийг сонгож хэрэглэж байгаа та бүхэнд баярлалаа.

Хувьцаа эзэмшигч: Сайн байна уу. Намайг Амар-отгон гэдэг. Би санхүү эдийн засгийн дээд сургуульд сурьдаг. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Түмэн шувуут ХК нь махны экспортод оролцон гэж ярьж байсан. Энэ ажилд яаж оролцох вэ. Өөрсдийнхөө үйлдвэрлэдэг өндөгөө олон улс руу экспортлох уу.

Л.Эрхэмбаяр: Бид Монгол улсын өндөгний хэрэглээний 40-50%-ыг л хангаж байгаа. Тэгэхээр эхний зорилго бол экспортлох биш 100% дотоодын өндөгний хэрэглээг хангах гол зорилготой байна. Харин махны экспорт бол манай монгол улсад бол зөвхөн өсвөр хонины махыг жил болгон 60,000 тонныг экспортлох боломж байгаа. Манай улс 31,000,000 толгой хоньтой. Тэгээд 60,000 тонн мах экспортлоход 3 хан сая толгой хонь орно. Энэ ажил дээр бид нар төвлөрч байна. 2026 он гэхэд энэ ажил бол маш том эргэлт гарсан монгол улсыг хамарсан, 45,000 ажлын байр оролцсон маш том кластер төсөл болно гэдэгт бид нар эргэлзэхгүй байгаа. Энэ ажлын эхлэлийг тавиад явж байна.

Хувьцаа эзэмшигч Өнөрбат: 1-рт Хувьцаа нэмж гаргах төлөвлөгөөтэй байгаа гэж байсан. Яг хэдэн төгрөгөөр хувьцаа нэмж гаргахаар тооцож байгаа вэ. 20 тэрбум гэхээр ойролцоогоор 40 сая ширхэг хувьцаа нэмж гаргана гэж ойлгож болох уу. 2-рт хувьцааны ханш унаад байгаа шалтгаан нь Болд захирал фээсбүүк хуудас дээрээ ОХУ-аас нийлүүлдэг өндөгний тэжээлийн үр тариа түүхий эд тасалдаж байна гэж бичсэн байсан. Би тэрнээс болж хувьцааны үнэ ханш уналаа гэж ойлгож байгаа. Энэ дээр ямар арга хэмжээ авч байна вэ? Хэрвээ ОХУ, Украйны дайн хурцдаад ирэх юм бол өндөгний борлуулалт яах вэ? Ямар хэмжээнд хүрэх вэ? Энэ тал дээр хариу авмаар байна.

Ж.Болд: Би өөрийн сошил хуудсаар болж байгаа бодит мэдээллийг л өгч байгаа. Бид нар бас дандаа гоё мэдээллийг хүмүүст өгөөд байж болохгүй. Болж байгаа, тулгарч байгаа мэдээллээ үнэн зөв өгөх ёстой. Тэгэхдээ тэр тасалдсан зүйл нь дан тэжээл биш тэжээлийн нэг орц найрлага, түүхий эд Шар буурцгийн шахдас юм. Уургийн агууламж өндөртэй бүтээгдэхүүн. ОХУ-аас авдаг байсан түүхий эд маань засгийн газрынх нь шийдвэрээр хилийн хоригт нь орчихсон байна. ОХУ-аас авах боломжгүй байх тохиолдолд БНХАУ-аас ч авах боломжтой байгаа. Гэхдээ тээвэр нь гацаатай байгаа. Удсан ч гэсэн авах боломжтой байгаа. Эсвэл Казакстанаас ч авах боломжтой байгаа. Бид хэд хэдэн эх үүсвэрүүдээс судлаад татан авалтуудаа хийгээд явж байна. Энэнээс болоод хувьцааны үнэ унаж байгаа гэж бас ойлгож болохгүй. Хувьцааны үнийг унагахад хүргэх мэдээлэл гэж ойлгож болохгүй юм. Асуудлыг нуугаад байж болохгүй. Мэдээллээ нээлттэй өгөх нь зөв гэж бодсоны үүднээс тийм мэдээлэл хийсэн байгаа. Миний зүгээс өгсөн мэдээлэл бол тэжээлийн түүхий эдийн үнэ өсөх

эрсдэлтэй болж ирж байна. Үүнээс үүдэн өндөгнийхөө үнийг өсгөхөөс өөр аргагүй болж ирж байна гэдэг мэдээллийг өгч тайлбарлах нь зүйтэй байх. 2-рт нэмж хувьцаа гаргах талаар дөнгөж өнөөдөр л олон нийтэд өгч байна. Энэ асуудал маань нийтдээ бид 15 орчим хувийн хувьцаагаа худалдана. Гэвч өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн тоо бол тодорхой хэмжээгээр багасна. Хувь хэмжээ багассан ч илүү том Түмэн шувуут ХК-ийн хувьцаа эзэмшигч болох боломжтой гэсэн тооцоолол гарч байгаа. Энэ мэдээллийг бид цаашдаа ямархуу үнэтэй ямар хувиар нэмж хувьцаа гаргах уу гэсэн тооцооллыг гаргаж дуусгаад тодорхой мэдээлэл өгнө.

Тэжээлийн үйлдвэр тахианыхаа тэжээлийг 100% хангаж чаддаг уу?

Л.Эрхэмбаяр: Манай тэжээлийн үйлдвэр өөрийнхөө өндөглөгч тахианы үйлдвэрийг 100% хангаад дээрээс нь энэ жил ковид гарсантай холбоотой 8-9 шувууны аж ахуйг тахианы тэжээлээр давхар хангаж ажиллаж байгаа. Сардаа 200 гаруй тонн тэжээлээр бусад аж ахуй нэгжүүдэд худалдаж байгаа.

Хувьцаа эзэмшигчид үйлдвэртэй танилцаж болох уу?

Л.Эрхэмбаяр: Болно. Энэ үйл ажиллагааг зохион байгуулах уу. Болд захирал аа?

Ж.Болд: Болно оо. Хөтөлбөр гаргаад, хуваарь гаргаад зохион байгуулна. Ковидоос болж хориотой байсан. Одоо хуучин журмаараа зохион байгуулаад явна.

Хувьцаа эзэмшигч: Нэмж хувьцаа гаргавал Компанийн төвлөрлийн 75% хэд болж буурах вэ?

Л.Эрхэмбаяр: Би нийт хувьцааны 15%-д хувьцаа гаргана гэж тооцож байгаа. Тэр хэмжээгээр л буурах байх гэж тооцсон. Ер нь бол хэдэн хувь буурахыг СЗХ болон аудит, андрайтер хийх компаниудын тооцооллоор гардаг.

Хувьцаа эзэмшигч Далантайдорж: Хөрөнгө оруулалт татахад зориулж гаргаж байгаа хувьцааг хэзээ гаргах төлөвтэй байна.

Л.Эрхэмбаяр: Энэ жилийн 9-10 сард гэж төлөвлөж байна. Банкны IPO-тэй давхцахгүй.

Хувьцаа эзэмшигч: Дотоодын зах зээлд бусад аж ахуй нэгжүүдтэй, өрсөлдөгч компанитай яаж ажиллах стратеги барьдаг вэ?

Л.Эрхэмбаяр: Манай үнээр биш чанараар өрсөлдөнө гэсэн стратегийг байнга барьж ажилладаг.

Хувьцаа эзэмшигч Төгөлдөр: Бакей улс төртэй холбоотой хүн хараат бус гишүүнээр орсноор улс төрийн эрсдэлд орох магадлал ихсэх үү.

А.Бакей: Би уул шугамандаа эрдмийн хүн байгаа юм. Улсад 40-өөд жил ажиллаж байна. энэний 32 жил нь эрдмийн танхимд өнгөрөөсөн хүн. 8 жилийг нь улс төрийн танхимд өнгөрөөсөн хүн. Улс төрөөс үндсэндээ залхаж байна. Үлдсэн хугацаандаа эрдмийнхээ мөрөөр явж байвал надад их сайхан байна. Баярлалаа.

Л.Эрхэмбаяр: Бакей бол даалгасан ажлыг хариуцлагтай хийнэ. Бичиг хэргийн боловсруулалт сайтай. Асуудалд хариуцлагтай ханддаг хүн байгаа юм шүү.

Хувьцаа эзэмшигч Цолмон: Хөдөө орон нутагт түгээлт хэрхэн хийгддэг вэ? Эрдэнэтэд түгээлт тааруу байна.

Б.Мөнгөнтуяа: Манайх сүүлийн 3 жилд бид эрэлтээ дийлэхгүй байгаа. Өнөөдөр гарсан өндөг маргааш шууд худалдаанд гардаг. Өнөөдрийн байдлаар бид нийслэлийнхээ хэрэглээг чадан ядан хангаж байна. Үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдээд ч эрэлт маш их байгаа. Ялангуяа ковидын үед маш хүнд үеийг туулсан. Манай өндөгний эрэлт маш их байсан. Аль болох чадахаараа хэрэглэгчиддээ жигд хуваарилах ажлыг хүртэл хийж байсан. Одоо харьцангуй үйлдвэрлэлийн тоо хэмжээ урьдынхаасаа нэмэгдэж байгаа учраас хөдөө орон нутаг руу нийлүүлэх ажлыг энэ 2022 ондоо хийнэ ээ.

Ж.Болд: Үүн дээр нэмээд хэлэхэд манай борлуулалтын албаныхан их хүнд ажилласан гэж яриад байна. Тэрийгээ буруу ойлгуулаад байна л даа. Бид эрэлтээ дийлэхгүй ажиллаж байгаагаа хүнд нөхцөлд ажиллаж байна гэж яриад байна. Байгаа юмаа борлуулахын тулд, өндөгөө жигд хүргэхийн тулд хэцүү байгаа. Тэрнээс биш өндөгөө борлуулах гэж хэцүү ажиллаад байгаа юм биш. Энийгээ л буруу ойлгуулаад байх шиг байна.

Хувьцаа эзэмшигч Гантулга: Тахианы хэдэн хувиа даатгуулсан бэ? Тахианы өвчлөлөөс хамгаалах бодлогоо танилцуулна уу?

Ж.Болд: Бид тахиагаа даатгуулсан байгаа. Шувууныхаа байрыг даатгуулсан байгаа. Мандал даатгалд даатгуулсан байгаа. Шувууны аж ахуйд нэг ийм онцлог байдаг юм. Шувууны аж ахуй эрсдэлтэй юу гэж асуувал эрсдэлтэй гэж хэлнэ. Бид нарт эрсдэлээс хамгаалсан бодлого юу байдаг вэ гэвэл 1-рт шувууны аж ахуйд мөрдөх мал эмнэлэг ариун цэвэр, хорио цээрийн журам гэж байгаа. Энэ журмыг маш сайн мөрдөх хэрэгтэй. Хүмүүс ковидын үед зай барих нэг нэгэндээ контакт үүсгэхгүйгээр ажиллаж амьдрах нөхцөлд суралцаж байна. Бид энэ ажлыг бол нэлээн эртнээс хэрэгжүүлээд явдаг. Жишээлбэл: манай шувууны аж ахуйн ажилчид нэг байрнаас нөгөө байр луу орж ажилладаггүй. Өдрийн цайгаа уухдаа тусдаа цайны өрөөндөө орж уудаг гэх мэтчилэнгээр контакт үүсгэхгүйгээр ажилладаг. Мөн шувууны аж ахуйг эрсдэлгүйгээр авч явахад нэг гол ажил бол вакцинжуулалт байдаг. Шувууны халдварт өвчин дэлхий даяар байдаг хамгийн өндөр халдварт өвчины эсрэг 8 төрлийн өвчнөөс сэргийлсэн вакциныг хийдэг. Вакциныг хийснээрээ шувуу тухайн өвчний эсрэг дархлаатай болж эрсдлээс тодорхой хэмжээгээр хамгаалагддаг. Дээрээс нь даатгал байдаг. Үүнийг Мандал даатгалаар даатгуулсан байгаа. Үл хөдлөх хөрөнгө болон мал амьтны даатгал гэж хийгддэг.

Хувьцаа эзэмшигч Даваадорж: Надад асуулт бол байхгүй. Харин өнөөдрийн хурлаас бол маш олон мэдээллийг авч байна. Өмнө нь би мэдээлэлгүй байхдаа яагаад Түмэн шувуут ХК-д хувьцаа эзэмшигч болох шийдвэр гаргасан бэ гэхээр зөвхөн Л.Эрхэмбаяр гэдэг хүнийг хараад энэ хүн бол ёс зүйтэй зөв хүн байна гэдэг үндэслэлээр л хувьцаа авч байсан. Өнөөдөр бол шал өөр ойлголттой боллоо. Ирээдүйг харсан олон жил дарж болохуйц ийм үзэл бодлыг авч байна. Дээрээс нь Г.Мөнх-эрдэнэ ТУЗ-д орж ирж байгаа юм байна. Үүнийг маш

таатайгаар хүлээж авч байна. Монголын хөрөнгө оруулалтын зах зээлд шилдэгт орохуйц түүчээлэгч залуу байгаа гэж ойлгодог. Энэ хүний үгийг бас сонсохыг хүсч байна.

Г.Мөнх-эрдэнэ: Би 2 жил орчим ТУЗ-д Хараат бус гишүүнээр ажиллаж байна. Бид ТУЗ хурал болон Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр ч тэр асуух тодруулах зүйлүүдээ асуусаар ирсэн. Компани бол болж байгаагаа болж байна, болохгүй байгаагаа яг болохгүйгээр нь нээлттэй ил тод бодитоор нь мэдээлдэг. Энэ нь өөрөө хамгийн том үнэ цэнтэй соёл гэж миний хувьд боддог. Зарим хүмүүсийн хувьд хэтэрхий өөдрөгөөр болоогүй юмыг болж байгаагаар хэлдэг. Болж байгаа юмыг болохгүй байна гэж хэлэх нь өөрөө хөрөнгийн зах зээл дээр хувьцаа эзэмшиж байгаа хүмүүсийн эрх ашиг, уг хөрөнгийнх нь үнэ цэнд нь сөргөөр нөлөөлж байдаг. Тэгэхээр нь бүгдээрээ бодит байгаа мэдээллийг бодитоор нь хүргэх тэрийг бодитоор нь хүлээж авах нь өөрөө хамгийн чухал шүү. Мэдээж компанийн бизнес гэдэг бол өөрөө үргэлж эрсдэлгүй, үргэлж өсч байдаг зүйл гэж байхгүй. Хэзээ нэг өдөр ямар нэг шалтгаанаар эрсдэл гарахыг үгүйсгэхгүй. Тэгэхээр тэр үед нь нуудаг биш. Бодит үйл явдлыг нуудаг хаадаг биш яг л байгаагаар нь хэлдэг байх нь өөрөө та бүгдийн эрх ашгийг хамгаалж байгаа ийм үйл явдал юм шүү гэдгийг хэлэх байна. Та бүхэн хувьцааны ханшийг харж байгаа. Эхлээд 200 төгрөгөөр гарсан. Унасан, 800 хүртэл өссөн, унасан. Ахиад дараачийнхаа давалгааг эхлүүлэн өнөөдрөөс эхлэн ажиллаж байна. тэр нь юугаар илэрч байна вэ гэхээр нэмэлт хувьцаа гаргана гэдэг мэдээлэл өгч байгаагаар илэрч байна гэж ойлгож байгаа. Миний хувьд ойрын 2-3 жилд бол хувьцааны ханшийг 1000-аас дээш гэсэн тооцооллыг хийсэн байгаа. Гэхдээ энэ бол биелэгдэнэ гэсэн баталгаа байхгүй шүү гэдгийг хэлье. Яагаад гэвэл хэзээ ч хэн ч 100% бүгдийг алдаагүй хийдэггүй. Алдаж онож хийж явсаар байгаад сүүлдээ алддаггүй болдог, мэдлэгтэй болдог, туршлагатай болдог. Миний ойлгосноор бол өнөөдөр амжилттай явж байгаа хүмүүс цуцашгүй, няцашгүй явсан, унасан ч гэсэн босч ирсэн, босч ирсэн нь унаснаасаа олон байсан учраас өнөөдөр амжилтанд хүрч байгаа гэж ойлгож байгаа. За баярлалаа.

Хувьцаа эзэмшигч Мөнгөнсүх: Яагаад дотооддоо үйлдвэрлэдэг хэрнээ импортын өндөгнөөс өндөр үнэтэй байгаа вэ? Жишээ нь задгай өндөг 100₮ илүү байна. Цаашид буурах уу? Эсвэл ойролцоо очих уу? Уг нь тээврийн зардал гэхгүй тул хамаагүй хямд байх ёстой биш үү.

Л.Эрхэмбаяр: 1-рт импортоор оруулж ирж байгаа өндөг, өнөөдөр дөнгөж өндөглөж байгаа өндөг хоёр чанарын хувьд эрс тэс өөр байдаг. Тахиа өндөглөснөөс хойш 7 хоногийн дотор хүнсэнд хэрэглэж байгаа өндгийг сувиллын өндөг гэнэ гэсэн стандарт байгаа. Тэр нь юу гэсэн үг вэ гэхээр та хүүхдэдээ шинэ өндөг өгвөл тэр нь 97% таны хүүхдэд гэдсээр нь ходоодоор нь шимэгдээд шим тэжээл болоод очно. Хэрвээ таны хүүхдэдээ өгч байгаа өндөг 21-ээс дээш хоносон бол 57% нь л шингэнэ. Энэ хоёрын хооронд их зөрүү байгаа биз. Тийм учраас олон улсад бид нарын 100₮ өөр илүү гээд байгаа сувиллын өндөг нь угаасаа ОХУ-д ч үнэтэй байгаа. ОХУ-аас ямар өндөг орж ирдэг вэ? Агуулахад 14-ээс дээш хоног, сараас дээш хоног хадгалсан өндөг орж ирнэ. Тэндээ зарж байгаа сувиллын өндөгнүүд нь эндэхийн өндөгнөөс ч үнэтэй байгаа. Дэлхий дээр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа хүнс ч бай, хувцас ч бай, юу ч байсан дандаа үнэтэй байгаа. Үнэ бол зэрэглэлийг, зиндааг үнэ цэнийг тогтоож өгч байдаг. Манай компанийн тахианууд өдөр болгон 500кг яг та бидний идэж байгаа Янтагийн

ургамалын тос идэж байгаа. Энд байгаа хүмүүс нэг үйлдвэрээрээ очиж үзээрэй. Яг юу хэрэглэдэгийг нь үзээрэй. Бид нар дээд зэргийн улаан буудай, дээд зэргийн тос гэх мэт ийм юмаар тэжээж байгаа. Тэрийг эрхлүүлж байж, тансаг тэжээж байж чанартай өндөгөө авна. Тэгэхдээ ийм гээд үнээ хэтэрхий өсгөх биш дээр доор хоёрын дунд донжийг нь олох гэх мэт үнийн бодлогоо барина.

Үүгээр асуулт хариултын хэсэг өндөрлөв.

Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийг ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцууллаа.

Хурлын дарга Л.Эрхэмбаяр Хуралд оролцогсдод талархал илэрхийлснээр 17:55 цагт хурал өндөрлөв.

ТАНИЛЦСАН ХУРЛЫН ДАРГА :

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Л.ЭРХЭМБАЯР

Б.НЯМБАЯР